

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/121/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Аудитор: Б.Должинжав Утас: 70432545 цахим хаяг: Doljinjav.b@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
АОУС	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
УСНББОУС	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
ТТЗ	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
ТШЗ	<i>Төсвийн шууд захирагч</i>
ТБОНӨХБАҮХАТ	<i>Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай</i>
ЗДТГ	<i>Засаг даргын дамгын газар</i>

Агуулга

1.Төрийн аудитын байгууллагын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Залруулсан алдаа.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	17
Аудитын зөвлөмж.....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	17
4. Менежментийн захидал	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

1. ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА Л.БАТБАЯР ТАНАА

2021.02.05 № 947
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР



021020246

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	25,297,328.00	31,454,476.00
33	АВЛАГА	300,000.00	00.00
336	Зээлийн авлага	300,000.00	00.00
3362	Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	300,000.00	00.00
33621	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	300,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	24,997,328.00	31,454,476.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	141,500.00	00.00
354	Хангамжийн материал	24,855,828.00	31,454,476.00
35410	Бичиг хэргийн материал	00.00	100,000.00
35420	Аж ахуйн материал	22,949,100.00	29,447,748.00
35470	Бусад хангамжийн материал	1,906,728.00	1,906,728.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	597,810,640.28	637,394,209.60
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	597,810,640.28	637,394,209.60
392	Биет хөрөнгө	38,551,140.24	78,234,709.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,341,520.00	3,341,520.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-334,152.00	-668,304.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	47,482,246.00	41,606,136.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-43,419,443.97	-30,188,911.62
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	77,737,140.08	91,373,078.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	-54,154,773.44	-45,087,399.22
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,653,093.05	24,966,171.11
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,383,061.88	-11,564,724.78
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,000,000.00	6,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,371,427.60	-1,542,856.12
393	Биет бус хөрөнгө	559,259,500.04	559,159,500.08
39303	Бусад биет бус хөрөнгө	560,409,500.00	560,409,500.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-1,149,999.96	-1,249,999.92
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	623,107,968.28	668,848,685.60
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	623,107,968.28	668,848,685.60
51	Засгийн газрын хувь оролцоо	623,107,968.28	668,848,685.60
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	666,659,446.13	666,659,446.13
51101	Өмч: - төрийн	107,699,946.13	107,699,946.13
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	558,959,500.00	558,959,500.00
512	Хуримтлагдсан үр дүн	-43,789,520.92	1,951,196.40
51210	Өмнөх үеийн үр дүн	-43,789,520.92	-43,406,832.81
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	45,358,029.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	238,043.07	238,043.07
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	623,107,968.28	668,848,685.60

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	471,233,312.00	573,520,517.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,330,136.00	42,485,117.61
120	Нийтлэг татварын бус орлого	6,977,000.00	42,485,117.61
120003	Торгуулийн орлого	00.00	584,732.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,977,000.00	4,210,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		37,690,385.61
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	4,210,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,977,000.00	00.00
122	Тусламжийн орлого	1,353,136.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	1,353,136.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	462,903,176.00	531,035,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,281,204.00	73,632,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,217,000.00	31,684,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,812,874.00	32,361,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,251,330.00	4,375,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	5,212,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	412,394,200.00	457,403,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	412,394,200.00	457,403,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,227,772.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,227,772.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	470,505,557.27	528,123,096.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	470,505,557.27	528,123,096.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	453,956,949.27	519,965,681.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	324,188,544.00	371,155,829.00
210101	Үндсэн цалин	265,974,844.00	283,693,760.00
210102	Нэмэгдэл	43,490,800.00	39,916,119.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,722,900.00	37,850,000.00
210304	Урамшуулалт цалин		9,695,950.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,529,800.00	49,979,800.00
210201	Тэтгэврийн даатгал	27,560,200.00	35,171,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,242,400.00	3,702,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,593,900.00	2,961,800.00

210204	Ажилгүйдлийн даатгал	648,500.00	740,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,484,800.00	7,404,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,872,218.00	23,490,928.00
210401	Бичиг хэрэг	2,666,500.00	700,700.00
210402	Тээвэр, шатахуун	8,539,320.00	9,652,630.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,190,200.00	1,223,730.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	35,000.00	65,930.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,441,198.00	11,847,938.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,555,000.00	00.00
210604	Урсгал засвар	1,555,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	9,134,900.00	26,318,000.00
210702	Дотоод албан томилолт	9,134,900.00	26,318,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,405,204.00	32,412,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,281,304.00	30,998,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	336,000.00	336,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	179,500.00	363,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	53,900.00	101,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	53,000.00
210807	Газрын төлбөр	430,000.00	430,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	91,500.00	60,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	69,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,271,283.27	16,608,924.01
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	841,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,271,283.27	15,767,424.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,548,608.00	8,157,415.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,496,772.00	8,067,500.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,227,772.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,270,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,998,800.00	8,067,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	51,836.00	89,915.11
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,836.00	89,915.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	727,754.73	45,397,421.49
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	39,392.28
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	39,392.28
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-39,392.28
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	727,754.73	45,358,029.21

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	469,880,176.00	537,120,540.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,977,000.00	4,210,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,977,000.00	4,210,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,977,000.00	4,210,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	4,210,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,977,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	462,903,176.00	532,910,540.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,281,204.00	75,507,140.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,217,000.00	33,259,140.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,812,874.00	32,361,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,251,330.00	4,375,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	5,512,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	412,394,200.00	457,403,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	412,394,200.00	457,403,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,227,772.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,227,772.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	469,580,176.00	519,420,540.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	469,580,176.00	519,420,540.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	453,031,568.00	511,263,124.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	324,188,544.00	370,188,408.89
210101	Үндсэн цалин	265,974,844.00	282,726,339.89
210102	Нэмэгдэл	43,490,800.00	39,916,119.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,722,900.00	37,850,000.00
210104	Урамшуулалт цалин		9,695,950.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,529,800.00	49,979,800.00
210201	Тэтгэврийн даатгал	27,560,200.00	35,171,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,242,400.00	3,702,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,593,900.00	2,961,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	648,500.00	740,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,484,800.00	7,404,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,622,720.00	15,085,228.00
210401	Бичиг хэрэг	1,763,000.00	800,700.00

210402	Тээвэр, шатахуун	8,539,320.00	9,652,630.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,190,200.00	1,223,730.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	35,000.00	210,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,095,200.00	3,198,168.00
2105	Нормативт зардал	3,959,000.00	2,959,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,959,000.00	2,959,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,349,900.00	00.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,849,900.00	00.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	9,134,900.00	27,054,640.00
210702	Дотоод албан томилолт	9,134,900.00	27,054,640.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,405,204.00	41,703,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,281,304.00	40,290,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	336,000.00	336,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	179,500.00	363,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	53,900.00	101,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	53,000.00
210807	Газрын төлбөр	430,000.00	430,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	91,500.00	60,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	69,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	841,500.00	4,291,448.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	3,449,948.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	841,500.00	841,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,548,608.00	8,157,415.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,496,772.00	8,067,500.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,227,772.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,270,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,998,800.00	8,067,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	51,836.00	89,915.11
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,836.00	89,915.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	300,000.00	17,700,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	17,700,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	17,700,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	17,700,000.00
222001	Тоног төхөөрөмж	00.00	17,700,000.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-17,700,000.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	300,000.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	107,699,946.13	238,043.07	(54,737,624.54)	53,200,364.66
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	107,699,946.13	238,043.07	(54,737,624.54)	53,200,364.66
Тайлант үеийн үр дүн	-	-	39,181,317.68	39,181,317.68
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	666,659,446.13	238,043.07	(43,789,520.92)	623,107,968.28
2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	666,659,446.13	238,043.07	(43,789,520.92)	623,107,968.28
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	382,688.11	382,688.11
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	666,659,446.13	238,043.07	(43,406,832.81)	623,490,656.39
Тайлант үеийн үр дүн	-	-	45,358,029.21	45,358,029.21
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	666,659,446.13	238,043.07	1,951,196.40	668,848,685.60

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ЭЗА	Зардлын нэр төрөл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	461,563,400.00	461,523,484.89	-39,915.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	461,563,400.00	461,523,484.89	-39,915.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	453,963,400.00	453,955,984.89	-7,415.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	370,220,900.00	370,188,408.89	-32,491.11
210101	Үндсэн цалин	295,397,500.00	282,726,339.89	-12,671,160.11
210102	Нэмэгдэл	60,448,600.00	39,916,119.00	-20,532,481.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,374,800.00	37,850,000.00	23,475,200.00
210104	Урамшуулалт цалин		9,695,950.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,979,800.00	49,979,800.00	00.00
210201	Тэтгэврийн даатгал	35,171,000.00	35,171,000.00	00.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,702,200.00	3,702,200.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,961,800.00	2,961,800.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	740,400.00	740,400.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,404,400.00	7,404,400.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,946,600.00	13,945,228.00	-1,372.00
210401	Бичиг хэрэг	800,700.00	800,700.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	9,557,900.00	9,556,630.00	-1,270.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,223,800.00	1,223,730.00	-70.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устг	210,000.00	210,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,154,200.00	2,154,168.00	-32.00
2105	Нормативт зардал	2,960,000.00	2,959,800.00	-200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,960,000.00	2,959,800.00	-200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,700,000.00	7,700,000.00	00.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,700,000.00	7,700,000.00	00.00
2107	Томиллолт, зочны зардал	3,112,000.00	2,496,500.00	-615,500.00
210702	Дотоод албан томиллолт	3,112,000.00	2,496,500.00	-615,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,802,600.00	2,394,800.00	-407,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үй	1,650,000.00	1,243,000.00	-407,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	336,000.00	336,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	179,500.00	179,500.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,100.00	44,100.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00	00.00
210807	Газрын төлбөр	430,000.00	430,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний х	60,000.00	60,000.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	70,000.00	69,200.00	-800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,241,500.00	4,291,448.00	1,049,948.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,400,000.00	3,449,948.00	1,049,948.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	841,500.00	841,500.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,600,000.00	7,567,500.00	-32,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,600,000.00	7,567,500.00	-32,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,600,000.00	7,567,500.00	-32,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	461,563,400.00	461,523,484.89	-39,915.11
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	457,403,400.00	457,363,484.89	-39,915.11
132001	Орон нутгийн төсвөөс	457,403,400.00	457,363,484.89	-39,915.11
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,160,000.00	4,160,000.00	00.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,160,000.00	4,160,000.00	00.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	39.00	38.00	-01.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	00.00
620002	Гүйцэтгэх ажилтан	33.00	32.00	-01.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	00.00

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	

I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	75,507,140.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	65,507,140.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	65,007,140.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,140,000.00
210402	Тээвэр, шатахуун	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,044,000.00
2107	Томилолт, зочны зардал	24,558,140.00
210702	Дотоод албан томилолт	24,558,140.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,309,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,047,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	184,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	57,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	10,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	75,507,140.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	75,507,140.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	33,259,140.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,361,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,375,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,512,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3.АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Л.Батбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн орлого бүрдүүлэлт, зарцуулалт, бараа материалын дансны бүртгэл, НББ-ийн бодлогын баримт бичгийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 31-ээс 2021 оны 02 дугаар сарын 02-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Должинжав хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь “Аймгийн нутаг дэвсгэрт байгаль орчин, аялал жуулчлалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулж, иргэдэд экологийн боловсрол олгож, байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр мэдээллийн сан бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь хүн амын өсөлт, үйлдвэржилтийг дагалдан гарч буй байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, дасан зохицох, орчны бохирдлыг арилгахад гол үйл ажиллагаагаа чиглүүлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой бүрэн нийцээгүй байна.

Цар тахлын улмаас Байгаль орчин, аялал жуулчлалын газрын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой дотоод болон бусад хяналт, шалгалт 2020 онд хийгдээгүй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 470563.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4705.6 мянган төгрөгөөр тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 528123.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5281.2 мянган төгрөгөөр тооцсон болно

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 45740.8 мянган төгрөгөөр буюу 7.3%-аар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт нь үндсэн хөрөнгийн дансанд гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	25,297.3	31,454.5	6,157.2
33	АВЛАГА	300.0	-	(300.0)
35	БАРАА МАТЕРИАЛ	24,997.3	31,454.5	6,457.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	597,810.6	637,394.2	39,583.6
392	Биет хөрөнгө	38,551.1	78,234.7	39,683.6
393	Биет бус хөрөнгө	559,259.5	559,159.5	(100.0)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	623,107.9	668,848.7	45,740.8
51101	Өмч: - төрийн	107,699.9	107,699.9	-
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	558,959.5	558,959.5	-
512	Хуримтлагдсан үр дүн	(43,789.5)	1,951.3	45,740.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	238.0	238.0	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	623,107.9	668,848.7	45,740.8

Авлага дансны оны эхэн дэх 300.0 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлагыг аймгийн төрийн сангаас барагдуулж, оны эцэст тооцоогүй болсон байна.

Бараа материалын дансны 31454.5 мянган төгрөгийн үлдэгдэлд үндсэн хөрөнгийн шинж чанар бүхий 2 нэр төрлийн нийт 5571.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэгдсэн байна.

Энэ нь санхүүгийн байдлын тайланг үнэн зөв илэрхийлээгүй, бүртгэл тооцооллын холбогдох журам, стандартад нийцээгүй байна.

Үндсэн хөрөнгө данс 55390.4 мянган төгрөгөөр өссөн нь Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс 37690.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 09-ны 213 дугаар шийдвэрийн дагуу хүлээн авч, Төсвийн хөрөнгөөр Итмон ХХК-аас 7700.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ТЭХ-ыг үндсэн данснаас, Би Эм Жи Юу ХХК-аас 10000.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгслийг нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээс худалдан авч данс бүртгэлд тусгасан байна.

Тайлант хугацаанд 39317.5 мянган төгрөгийн хөрөнгийг аймгийн ИТХ-ын 2020 оны 01 сарын 16-ны 68 тоот тогтоолын дагуу акталж, данс бүртгэлээс хассан байна

Дансны код	Барилга, байгууламж	Тээврийн хэсэгсэл	Машин тоног төхөөрөмж	Тавилга эд хогшил	Бусад үндсэн хөрөнгө	Бусад биет бус хөрөнгө	НИЙТ ДҮН
	39201	39203	39205	39207	39214	39303	
Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	3,341.5	47,482.2	77,737.1	16,653.1	6,000.0	560,409.5	711,623.5
Нэмэгдсэн	-	10,000.0	33,308.6	12,081.8	-	-	55,390.4
Худалдан авсан	-	10,000.0	5,169.1	2,530.9	-	-	17,700.0

Хандиваар	-	-	28,139.5	9,550.9	-	-	37,690.4
Хасагдсан	-	15,876.1	19,672.6	3,768.7	-	-	39,317.5
Акталсан	-	15,876.1	19,672.6	3,768.7	-	-	39,317.5
Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,341.5	41,606.1	91,373.1	24,966.2	6,000.0	560,409.5	727,696.4
Хуримтлагдсан элэгдлийн эцсийн үлдэгдэл	668.3	30,188.9	45,087.4	11,564.7	1,542.9	1,250.0	90,302.2
Үлдэгдэл өртөг	2,673.2	11,417.2	46,285.7	13,401.4	4,457.1	559,159.5	637,394.2

Биет бус хөрөнгөд Буянт багт 558959.5 мянган төгрөгийн үнэлгээтэй 10 га газар, 1450.0 мянган төгрөгийн өртөгтэй, 1250.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй программ хангамж бүртгэлтэй байна.

Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдэл 666659.4 мянган төгрөг нь улсын бүртгэл дэх төсвийн байгууллагын өмчийн дүнтэй тохирохгүй байна.

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Зөрүү
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	471,233.3	573,520.5	102,287.2
12	Татварын бус орлого	8,330.1	42,485.1	34,155.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,281.2	73,632.0	28,350.8
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	412,394.2	457,403.4	45,009.2

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 102287.2 мянган төгрөгөөр буюу 21.7%-аар өссөн нь үндсэн хөрөнгөд 37690.4 мянган төгрөгийн эд хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан, өмнөх оноос төсвийн санхүүжилт 45009.2 мянга, нэмэлт санхүүжилтийн дансны орлого 28350.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн зэргээс шалтгаалжээ.

Төсвийн байгууллагын өөрийн орлогын эх үүсвэрийг усны тухай хууль, журмын хүрээнд иргэн, аж ахуйн нэгж байгууллагад ус ашигласан дүгнэлт гаргах, мөн ус ашиглах, худаг гаргах зөвшөөрөл олгох зэргээр голчлон бүрдүүлжээ.

Тайлант хугацаанд 27 аж ахуйн нэгжид усны дүгнэлт гаргуулснаас 19 аж ахуйн нэгжийн усны зөвшөөрлийн эрх олгоогүй байдлаас дүгнэхэд төсвийн орлого бүрдүүлэх, усны нөөц баялгийг хууль, журмын дагуу зүй зохистой ашиглуулах бодлого төдийлөн үр дүнтэй хэрэгжихгүй байна. Мөн төсвийн орлого бүрдүүлэхэд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй, холбогдох тооцоо хийгдээгүй байна

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Зөрүү
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	470,505.6	528,123.1	57,617.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	324,188.5	371,155.8	46,967.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,529.8	49,979.8	9,450.0
2104	Хангамж, бараа материалын зардал	32,872.2	23,490.9	(9,381.3)
2107	Томилолт, зочны зардал	9,134.9	26,318.0	17,183.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,405.2	32,412.2	(5,993.0)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,826.3	16,608.9	7,782.6

213 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ

16,548.6 8,157.4 (8,391.2)

Нийт зардал өмнөх оноос 57617.5 мянган төгрөгөөр буюу 12.2%-аар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад материаллаг өөрчлөлтөд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл 56417.3 мянга, томилолтын зардал 17183.1 мянга, үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол 8496.1 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөө үзүүлсэн байна.

Дээрх зардлууд материаллаг хэмжээгээр өссөн шалтгаан нь Германы хамтын ажиллагааны GIZ төслөөс ITM-2020 үзэсгэлэн худалдаа УБ хотод зохион байгуулах арга хэмжээ зохион байгуулснаар нэмэлт санхүүжилтийн дансаар 23821.5 мянган төгрөгийг томилолтын зардал, Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоож нэмэгдүүлснээр цалингийн зардал нэмэгдэж, түүнчлэн тайлант онд үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалж элэгдлийн зардал өмнөх оны үзүүлэлтээс тус тус өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дансанд 382.7 мянган төгрөгөөр залруулга хийгдсэн нь 2019 онд нийгмийн даатгалын шимтгэлийн алдааны залруулгаас шалтгаалжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 569894.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 569894.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 108331.0 мянган төгрөгөөр бууруулж 461563.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсөв өмнөх онохоос 48169.2 мянган төгрөгөөр өссөний дийлэнхийг нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал эзэлж байгаа ба энэ нь Засгийн газрын тогтоол шийдвэрийн дагуу төрийн албан хаагчдын цалингийн сүлжээ, хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 461563.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 457403.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 4160.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс санхүүжилт бүрэн авч, үндсэн үйл ажиллагаанаас 4210.0 мянган төгрөгийн орлого, нийт 461613.4 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 461523.5 мянган төгрөгийг зарцуулж 89.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 461523.5 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардалд 453791.5 мянга, мэдээлэл сурталчилгааны зардалд 132.0 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардалд 7600.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

Хөтөлбөр	Зориулалт	Арга хэмжээ	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
71411	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	453,821.5	453,791.5	-30.0
71411	80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	132.0	132.0	0.0
71411	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	7,570.0	7,600.0	30.0
ДҮН			461,523.5	461,523.5	0.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн төсвөөс эрх шилжүүлсэн захирамжийн дагуу 10000.0 мянган төгрөгийг автомашины санхүүжилт, 18981.0 мянган төгрөгийн зуслангийн 00-ын санхүүжилт, бусад арга хэмжээний 3380.0 мянга, нийт 32361.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 4375.0 мянган төгрөгийн хөтөлбөрийн санхүүжилт, урьд онд татан төвлөрүүлсэн 300.0 мянга, Германы хамтын ажиллагааны GIZ PAO төсөл, МоЭнКо компаниас төсөл хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилт 38471.1 мянга, нийт 75507.1 мянган төгрөгийн эх үүсвэрийг хууль, журмын дагуу бүрдүүлжээ.

Дээрх эх үүсвэрээс 10000.0 мянган төгрөгийг суудлын автомашин худалдан авахад, 262.0 мянган төгрөгийг автомашины татвар, даатгал, үйлчилгээнд, 16906.2 мянган төгрөгийг зуслангийн 00-ын санхүүжилтэд, 48338.9 мянган төгрөгийг зориулалтын дагуу холбогдох хөтөлбөр, арга хэмжээнүүдэд зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 159 мэдээллээс 2 мэдээллийн хугацаа болоогүй, 157 мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, цэгцтэй, хэрэглэгчдэд ойлгомжтой байдлаар мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 2 зөвлөмжийг 100 хувь биелүүлжээ.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2		2				100%
Нийт дүн	2		2				100%

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 24668.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9194.6 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 15474.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Буянт голын зуслангийн айлуудын сайжруулсан, боловсронгуй 11 жорлонг хариуцагч байгууллагад хүлээлгэж өгөөгүй байхад 8453.1 мянган төгрөгийн хөрөнгө зардлаар бүртгэж, данс бүртгэлээс хассан
2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын ангилал хооронд 741.5 мянган төгрөг залруулан бүртгэсэн

Нийт 9194.6 мянган төгрөгийн бүртгэлийн алдаа, зөрчилд залруулга хийв.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар бичигдсэн акт, албан шаардлага байхгүй болно.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 15474.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Төсвийн орлого бүрдүүлэлтийн талаар

1.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд 27 аж ахуйн нэгжид усны дүгнэлт гаргуулснаас 19 аж ахуйн нэгжийн усны зөвшөөрлийн эрх олгоогүй байдлаас дүгнэхэд төсвийн орлого бүрдүүлэх, усны нөөц баялгийг хууль, журмын дагуу зүй зохистой ашиглуулах бодлого төдийлөн үр дүнтэй хэрэгжихгүй байна. Мөн төсвийн орлого бүрдүүлэхэд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй, холбогдох тооцоо хийгдээгүй байна

1.2. Эрсдэл: Төсвийн орлого бүрдэх нөөц боломж алдагдах, түүнчлэн усны тухай хууль, журам үр дүнтэй хэрэгжихгүй байх

1.3. Өгсөн зөвлөмж: Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтуудтай нийцүүлж төсвийн орлого бүрдүүлэх, усны нөөц баялгийг хууль, журмын дагуу зүй зохистой ашиглах бодлогыг хэрэгжүүлэх

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Буянт голын зуслангийн айлуудын сайжруулсан, боловсронгуй жорлон хийх 17796.0 мянган төгрөгийн гэрээний ажлын төсөвт өртөг, ажлын даалгаварт хяналт хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

2.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгө үрэлгэн зарцуулагдах

2.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 6.4.4-д “Хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон

шалгаруулалтын аргаар сонгох”, гэсэн заалтуудтай нийцүүлж гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын даалгавар, төсөвт өртгийн тооцооллыг хянаж, төсвийн хөрөнгийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

3.1. Илрүүлэлт: НББ-ийн бодлогын баримт бичигт байгууллагын үйл ажиллагааны бүртгэлийн онцлогийг тусгаагүй, түүнчлэн мөрдөгдөж байгаа санхүү, бүртгэлийн шинэчлэгдсэн хууль, журамтай нийцээгүй

3.2. Эрсдэл: НББ-ийн хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх, мөн бүртгэлийн бодлого, зарчим тодорхой бус

3.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтуудтай нийцүүлж нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагааны бүртгэлийн онцлогт тохируулан боловсруулж, баталж, хэрэгжүүлэх

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4. Бараа материалын данстай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт: Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанар бүхий 5571.0 мянган төгрөгийн 2 хөрөнгө, мөн биет бус хөрөнгөд 1450.0 мянган төгрөгийн программ хангамжийн ангилал буруу бүртгэсэн байна.

4.2 Эрсдэл: Энэ нь санхүүгийн байдлын тайлан буруу илэрхийлэгдэх, бүртгэл тооцооллын холбогдох журам, стандартад нийцэхгүй байх.

4.3 Өгсөн зөвлөмж: УСНББОУС-Бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэлийн стандарттай нийцүүлж эд хөрөнгийг ангилан бүртгэх

4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Алдаа, зөрчлийн хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 05 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ХОА-2021/121/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Байгаль орчин, аялал жуулчлалын газар		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
1	Тайлант хугацаанд 27 аж ахуйн нэгжид усны дүгнэлт гаргуулснаас 19 аж ахуйн нэгжийн усны зөвшөөрлийн эрх олгоогүй байдлаас дүгнэхэд төсвийн орлого бүрдүүлэх, усны нөөц баялгийг хууль, журмын дагуу зүй зохистой ашиглуулах бодлого төдийлөн үр дүнтэй хэрэгжихгүй байна. Мөн төсвийн орлого бүрдүүлэхэд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй, холбогдох тооцоо хийгдээгүй байна	-	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Л.Батбаяр, Г.Чанцалдулам
2	Буянт голын зуслангийн айлуудын сайжруулсан, боловсронгуй жорлон хийх 8453.1 мянган төгрөгийн гэрээний ажлын төсөвт өртөг, ажлын даалгаварт хяналт хангалтгүй хэрэгжүүлсэн байна.	8453.1	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Л.Батбаяр, Г.Чанцалдулам
3	НББ-ийн бодлогын баримт бичигт байгууллагын үйл ажиллагааны бүртгэлийн онцлогийг тусгаагүй, түүнчлэн мөрдөгдөж байгаа санхүү, бүртгэлийн шинэчлэгдсэн хууль, журамтай нийцээгүй		Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Л.Батбаяр, Г.Чанцалдулам
4	Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанар бүхий 5571.0 мянган төгрөгийн 2 хөрөнгө, мөн биет бус хөрөнгөд 1450.0 мянган төгрөгийн программ хангамжийн ангилал буруу бүртгэсэн байна.	7021.0	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Л.Батбаяр, Г.Чанцалдулам
5	Буянт голын зуслангийн айлуудын сайжруулсан, боловсронгуй 11 жорлонг хариуцагч байгууллагад хүлээлгэж өгөөгүй байхад 8453.1 мянган төгрөгийн хөрөнгө зардлаар бүртгэж, данс бүртгэлээс хассан	8453.1	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Л.Батбаяр, Г.Чанцалдулам
6	Санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын ангилал хооронд залруулан бүртгэсэн	741.5	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Л.Батбаяр, Г.Чанцалдулам
	ДҮН	24668.7			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР